



“СҮРҮЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ САТРЕПС ХАМТАРСАН ТӨСӨЛ, 2020-2025 ОН”

Төслийн нэр:

СҮРҮЕЭ, ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ

Санхүүжүүлэгч:

Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны байгууллага (JICA), Японы эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн агентлаг (AMED)

Төслийн удирдагч:

Такаши Кимура, Хоккайдо их сургуулийн мал эмнэлгийн факультетын профессор

Төслийн захирал:

Д.Баярболд, ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга

Хэрэгжүүлэгч байгууллагууд:

Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Японы Хоккайдо их сургууль Мал эмнэлгийн факультет, Зоонозтой тэмцэх судалгааны төв, Японы Сүрьеэгийн эрдэм шинжилгээний хүрээлэн

Төслийн зорилго:

Сүрьеэ, ям өвчнийг нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй хянах тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх

Төслийн бодит үр өгөөж

- Монгол улсад Био-аюулгүй байдлын 3-р зэрэглэлийн иж бүрэн лаборатори, халдварт өвчиний үүсгэгчийн геномийн бүрэн дараалал тогтоох лабораторийг байгуулан холбогдох багаж, тоног төхөөрөмж, оношлуураар хангана.
- Хүн, мал эмнэлгийн салбарын боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаадын урт богино хугацааны сургалтад 20 орчим мэргэжилтэн, судлаачдыг хамруулна.
- Монгол улсад нэвтрүүлж байгаа оношилгооны дэвшилтэт шинэ технологи, багаж төхөөрөмжийг суурилуулах, ажиллагааг жигдүүлэх, нутагшуулах, зоонозын 2 өвчиний тандалт, оношилгоо, эмчилгээний удирдамжийг хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.
- Япон улсын профессор, эмч, мэргэжилтнүүд Монгол судлаачидтай судалгааг хамтран гүйцэтгэж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.



ТӨСЛИЙН
ҮЙЛ ЯВЦ

Төслийн хүрэх үр дүн:

- Халдварт зооноз өвчиний оношлох шинэ технологид суурилсан хуурай ЛАМП (dry LAMP), Иммунохроматографийн тест (ICT) зэрэг шинжилгээний түргэвчилсэн оношлуурыг зохион бүтээж *Mycobacterium bovis* ба *Burkholderia mallei*-ийн халдвартыг илрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх замаар Монгол Улсад одоогийн хэрэглэгдэж байгаа сүрьеэ, ям өвчнийг оношлох аргыг шинэчилнэ.
- Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зоонозын халдвартын эрсдэлийн үнэлгээ хийж, бодит нөхцөл байдлыг тодорхойлно.
- Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зооноз өвчиний тархалт, халдварталтын бодит нөхцөл байдлыг ийлдэс судлал, молекул биологийн аргаар тогтооно.
- Нэгэрүүл мэнд (One health) үзэл баримтлалд тулгуурласан зооноз халдварт өвчинийг хянах платформыг бий болгоно.

